

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**I. ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ.**

Компани 2023 онд 14 төсөвт байгууллага, 111 аж ахуйн нэгж, 1170 айл өрх, нийт 1295 хэрэглэгчтэй дулааны эрчим хүч, цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулах гэрээ байгуулан ажилласан.

1. Дулааны эрчим хүч

Тайлант онд

39.2 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 40.9 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн 104.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн түгээх шугамын шинэчлэлийн ажлаас шалтгаалан 7, 9 дүгээр саруудад дулаан үйлдвэрлэлийн төлөвлөгөө тасарсан ч 1, 4, 11, 12 дугаар саруудад гадна агаарын хэм хүйтэн байсантай холбоотой дулаан үйлдвэрлэлийн төлөвлөгөө 4 хувиар давсан үзүүлэлттэй байна.

Сүлжээний нэмэлт усны зарцуулалт төлөвлөгөөнөөс 1.49 мян.м³-ээр буурч 22.1 мян.м³ ыг зарцуулсан байна. Усны алдагдалтай холбоотой дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан, шугам сүлжээнд гарсан гэмтлийг устгаж, түгээх шугамын шинэчлэлийн ажлыг үе шаттай хийж байгаа зэргээс шалтгаалан нэмэлт усны алдагдал багассан. Мөн хуучин тосгоны 2 давхар байрууд нь хэрэгцээний халуун усны шугамгүй учир хэрэглэгчид сүлжээний усыг зүй бусаар ашиглаж нэмэлт усны зарцуулалтыг ихэсгэдэг байдалд хяналт тавьж хэрэглэгчдээр эргэлт, ухуулга сурталчилгаа хийх, системд тавьсан крантыг авч заглушка тавих зэрэг ажил зохион байгуулан ажилласан. Үүнтэй уялдан 20.2 тонн технологийн давс хэрэглэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 15.3 тонн давс хэрэглэж, 4.9 тонн давсыг хэмнэсэн буюу давсны хэрэглээ 24.3 хувиар буурсан байна.

2. Ус хангамж, ариутгал татуурга

308.9 мян.м³ ус олборлохоос 254.7 мян.м³ ус олборлон 82.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Тоолууржилт болон хэрэглэгчдийн усны зохистой хэрэглээ бий болж байгаагаас ус олборлолт буурсан.

Одоогийн байдлаар төсвийн байгууллага 100 хувь, аж ахуй нэгж, байгууллагууд 100 хувь, айл өрхийн 95,5 хувь нь усны тоолуур суурилуулан тооцоо хийж байна. 2023 онд 35 айл өрхөд 59 ширхэг, 13 ААНБ-д 16 ширхэг, нийт 75 тоолуур шинээр суурилуулсан.

271.2 мян.м³ бохир ус татан зайлуулахаас гүйцэтгэлээр 222.1 мян.м³ бохир усыг татан зайлуулсан.

Үндсэн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг мөн үетэй харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

№	Нэр	Хэмжих нэгж	2022 он	2023 он		Зөрүү	
			гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос	төлөвлөгөөнөөс
1	Үйлдвэрлэсэн ДЭХ	мян.Гкал	38.2	39.2	40.9	2.7	1.7
2	Дотоод хэрэглээ	мян.Гкал	3.2	3.2	3.2	0	0
3	Түгээсэн ДЭХ	мян.Гкал	35.0	36.0	37.7	2.7	1.7
4	Нүүрс	мян.тн	14,5	14.4	14.0	-0.5	-0.4
5	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/гкал	203.1	196.9	191.9	-11.2	-5.0
6	Нэмэлт ус	мян.тн	22.1	23.4	22.1	0	-1.3
7	Давс	мян.тн	17.0	20.2	15.3	-1.7	-4.9
8	Цэвэр ус	мян.тн	300.0	308.9	254.7	-45.3	-54.2
9	ЦЭХ-ний хэрэглээ	мян.кВт	2 226.5	2 304.6	2 177.1	-49.4	-127.5

Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд тайлант онд 2 304.6 мян.кВт цахилгаан эрчим хүч хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2 177.1 мян.кВт цахилгаан эрчим хүч хэрэглэн 127.5 мян.кВт буюу 5.5 хувиар цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарган ажилласан.

Халаалтын бус улирал буюу 7 сард хэрэгцээний халуун ус түгээн ажиллахаар төлөвлөсөн боловч шугам шинэчлэлийн ажлаас шалтгаалан зуух галлаагүйгээс, мөн насосуудад давтамж хувьсгуур суурилуулж усны хэрэглээ, ачаалалд тохируулан ажиллагааны ашигтай горимыг тогтоон, хувьсах горимоор ажиллуулах, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжөөр шинэчлэл хийх зэргээр цахилгаан эрчим хүчний хэрэглээг хэмнэж ажиллаж байна.

Хэрэглэгчдээс нийт 1 439 дуудлага хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан. Засварын ажил үйлчилгээний орлого 11,7 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Дуудлагыг төрлөөр нь ангилбал:


Дуудлагын төрөл	х.н	Халаалт	Хэрэгцээний халуун ус	Цэвэр ус	Бохир ус	Тоолуур	Бусад	Бүгд
2022 он	тоо	177	120	310	249	132	315	1 303
2023 он	тоо	191	112	352	340	93	351	1 439

II. САНХҮҮГИЙН ТАЛААР

Тайлант онд 4,339.4 сая төгрөгийн борлуулалт орлого хийхээр төлөвлөн 4,327.3 сая төгрөгөөр борлуулалт орлого хийж 99.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Эрчим хүчний алдагдлын татаас 881.8 сая төгрөгийн санхүүжилт авч, зардлыг 151.1 сая төгрөгөөр хэмнэн, 139.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Нийт орлого	4,339.4	4,327.3	(12.0)	99.7
Үүнээс: Үндсэн үйл ажиллагаа	3,365.3	3,314.3	(51.0)	98.5
Үндсэн бус үйл ажиллагаа	92.2	131.1	38.9	142.1
Татаас санхүүжилт	881.8	881.8	0.0	100
Нийт зардал	4,339.4	4,188.3	(151.1)	96.5
Цэвэр ашиг/алдагдал/	0.0	139.0	139.0	0.0
БО-ын 1 төгрөгт ногдох зардал	1.29	1.26	(0.03)	7.6

Санхүүгийн үзүүлэлтийг графикаар харуулбал:



Үндсэн үйлдвэрлэлээс 3 365.3 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр 3 314.4 сая төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын төлөвлөгөөг 98.5 хувиар биелүүлжээ.


Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын задаргаа.

Бүтээгдэхүүн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2023 он	
			Төлөв-өөс	хувь
Цэвэр ус	186.6	228.3	41.7	122.4
Бохир ус	154.9	193.0	38.1	124.5
Хэрэгцээний халуун ус	26.0	31.4	5.4	120.6
Халаалт	2,997.8	2,861.6	(136.2)	95.4
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,365.3	3,314.3	(51.0)	98.5

Б

орлуулалтын төлөвлөгөөгөөр 186.6 сая төгрөгийн цэвэр ус борлуулахаас 228.3 сая төгрөг буюу 122.4 хувь, 154.9 сая төгрөгийн бохир ус татан зайлуулахаар төлөвлөснөөс 193.0 сая төгрөг буюу 124.5 хувь, 2,997.8 сая төгрөгийн дулааны эрчим хүчний борлуулалт хийхээс 2,861.6 сая төгрөг буюу 95.4 хувь, 26.0 сая төгрөгийн хэрэгцээний халуун усны борлуулалт төлөвлөснөөс 31.4 сая төгрөг буюу 120.6 хувь тус тус биелүүлжээ.

Борлуулалтад эзлэх хувийн жинг графикаар харуулав



Борлуулалт дутуу хийгдсэн шалтгаан:

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтаас дулааны эрчим хүчний борлуулалт 51.0 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ус дулаан түгээх шугам шинэчлэлийн ажлын гүйцэтгэл хугацаа хоцролттой байснаас шалтгаалан 9 дугаар сард дулаан үйлдвэрлэл тасарч хуучин тосгоны төсөв, ААНБ, айл өрхийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүч дутуу хангасан байна.

Үндсэн бус үйл ажиллагаанаас 92.3 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр 131.2 сая төгрөгийн орлого оруулж 142.1 хувийн биелэлттэй байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
Дулааны суурь хураамж	41.2	38.5	-2.7
Цэвэр, бохир усны суурь хураамж	43.4	46.2	2.8
Засвар, ажил үйлчилгээ	7.6	40.8	33.2
Алдангийн орлого	0.0	5.7	5.7
Дүн	92.2	131.2	39.0

ЗАРДЛЫН ТАЛААР:

Нийт зардал 4,339.4 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,188.4 сая төгрөгийн зардал гарч 151 сая төгрөг буюу 96.5 хувиар хэмнэлттэй байна.

Зардлын хэмнэлт:

Цалин, НДШ зардал - 129.2 сая төгрөг хэмнэсэн байна. 5 ажлын байранд 9 орон тоо дутуу ажилласан ба 6 орон тоог хавсран ажиллуулсан.

Цахилгааны зардал - 22.5 сая төгрөгийн цахилгааны хэмнэлт гарсан нь мөн шугам шинэчлэлийн ажил хугацаа хоцорсонтой холбоотой дулаан үйлдвэрлэл тасарсан.

Шатахууны зардал -6.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Ажилчдын унаа 5 дугаар сараас 12 дугаар сар хүртэл хугацаанд үйлчилгээнд яваагүй.

ТУЗөвлөлийн зардал- 1.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Бичиг хэрэг томилолтын мөн нарийн бичгийн даргын утасны төлбөрөөс хэмнэлт үүссэн.

Зардлын хэтрэлт:

Албан томилолтын зардал- 5.4 сая төгрөгөөр хэтэрсэн нь 2020-2022 онуудад ковидын улмаас онлайн аар хийгддэг байсан сургалт зөвлөгөө танхимаар хийгддэг болсоноор төлөвлөгдөөгүй томилолтууд гарсан.

Бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардал- 2023 онд аудитын байгууллага өөрчлөгдснөөр төлөвлөгдөөгүй аудитын төлбөрөөр хэтэрсэн.

Зардлын задаргаа

мян.төгрөг

№	Зардлын төрөл	12 сар		Өссөн дүн		Зөрүү
		төлөв	гүйц	төлөв	гүйц	
1	Цалин	127,944.00	160,579.70	1,535,328.20	1,423,673.41	-111,654.80
2	НДШимтгэл	18,551.90	23,154.10	222,622.60	205,058.57	-17,564.00
	ДҮН	146,495.9	146,495.90	183,733.90	1,757,950.80	1,628,731.98
3	Урсгал засвар	552.3	320	75,116.80	74,745.17	-371.6
4	Хангамжийн материал	2,678.40	3,139.70	18,179.60	18,046.42	-133.2
5	Туслах материал	2,000.90	3,266.20	15,810.00	13,626.20	-2,183.80
6	Цахилгаан эрчим хүч	72,297.70	72,938.60	548,667.80	526,105.07	-22,562.70
7	Дотоод хэрэгцээ	25,574.70	20,326.80	189,572.60	189,572.60	-
8	Нүүрс	129,213.00	129,337.80	752,940.90	748,411.13	-4,529.80
9	ТУЗ-ийн зардал	6,896.80	6,890.00	79,210.00	77,869.01	-1,341.00
10	Холбоо	549	390.4	6,588.30	4,931.80	-1,656.50
11	Бичиг хэрэг	904	1,807.50	5,961.10	5,439.04	-522.1
12	Албан томилолт	634.2	264	7,797.00	13,288.00	5,491.00
13	ҮХ-н элэгдэл	37,156.20	37,890.50	445,874.30	445,810.50	-63.8
14	Хөдөлмөр хамгаалал	2,559.50	4,168.50	80,161.80	80,127.00	-34.8
15	Шатахуун түлш, тос	8,170.40	8,286.50	73,667.30	67,017.21	-6,650.10
16	Дээж шинжилгээ	375	553	3,018.60	1,665.88	-1,352.70
17	ҮХХ-н татвар	1,240.70		6,655.10	6,635.06	-20
18	Газрын татвар	920.4		2,583.80	1,070.12	-1,513.70
19	АТӨЯХ-н татвар			832.6	805.1	-27.5
20	Усны нөөц ашиг. татвар	110.7	241.8	1,610.70	1,741.79	131.1
21	Бусдаар гүйц.ажил	4,898.30	6,782.30	52,345.30	59,399.69	7,054.40
22	Нийгэм САХэмжээ	3,540.00	3,245.50	39,865.00	40,475.34	610.3
23	Сургалт	985	3,000.00	7,465.00	7,282.68	-182.3
24	Бусад татвар	1,385.80		1,385.80	-	-1,385.80
25	Сэлбэг хэрэгсэл	3,357.00	2,669.90	17,720.00	14,253.87	-3,466.10
26	Гүйцэтгэх удирдлагын зардал	7,687.90	16,141.70	92,255.40	86,094.50	-6,160.90
27	Байгаль орчны нөлөөлөл		2,530.50	2,530.50	2,530.50	-
28	Усны зардал	4,768.00	4,737.70	34,866.00	34,866.00	-
29	ОАТатвар		15,652.10	-	15,652.10	15,652.10
30	Бусад зардал		3,700.10	-	11,444.67	11,444.70
31	Ахмадын сан			10,200.00	10,700.00	500
32	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	8,580.00		8,580.00		-8,580.00
	Нийт зардлын дүн	473,531.80	532,014.80	4,339,412.10	4,188,338.40	-151,073.70

- АВЛАГА

Үзүүлэлт	2023.01.01	2023.12.31	өсөлт + бууралт –
Төсөв	0.9	2.5	1.5
ААНБ	152.1	169.8	17.7
Айл өрх	64.4	39.6	(24.7)
Бусад авлага	6.3	8.1	1.8
НИЙТ ДҮН	223.7	220.1	(3.6)

Оны эхнээс нийт авлага 3.6 сая төгрөгөөр буурсан байна.

- Төсвийн байгууллагуудын санхүүжилт дутуу төвлөрснөөс шалтгаалан авлага нь 1.5 сая төгрөгөөр өссөн.

- Айл өрхөөс авах авлага 24.7 сая төгрөгөөр буурсан.

- Аж ахуйн нэгж байгууллагуудын авлага 17.7 сая төгрөгөөр өссөн нь “Шарын гол” ХК-ийн ус дулааны хэрэглээгээр өссөн байна.

- Бусад авлага 1.8 сая төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын программын шинэчлэлтэй холбоотойгоор хөдөлмөрийн чадвар алдсан ажилтнуудын тооцоо авлагаар бүртгэгдсэн.

- Цаашид авлага бууруулах аян зохион байгуулж борлуулалтын байцаагч бүрээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

- **ӨГЛӨГ**

Үзүүлэлт	2023.01.01	2023.12.31	өсөлт + бууралт -
Дархан ДЦСтанц	197.8	189.3	(8.5)
Татвар	655.6	721.7	66.1
НДШ	431.2	61.3	(369.9)
Бусад өглөг	50.3	19.4	(30.9)
ДҮН	1,334.9	991.7	(343.2)

Нийт өглөг 343.2 сая төгрөгөөр буурсан байна.

- Татварт тайлант онд нийт 301.8 сая төгрөг төлсөн боловч НӨАТатварт 433.5 сая төгрөгийн ноогдуулалт хийгдэж 51.1 сая төгрөгөөр өссөн.

- НДШ-ийн өглөгт 404.9 сая төгрөгийн ноогдуулалт хийгдэж тайлант онд 774.8 сая төгрөг төлж, хуримтлагдсан өглөгийг 370.0 сая төгрөгөөр бууруулсан.

- Бусад өглөгийг 39.4 сая төгрөгөөр бууруулсан.

III. ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЫН ТАЛААР.

Техник тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлийн ажлыг компанийн техникийн бодлогын баримт бичиг, техник тоног төхөөрөмжид хийсэн эрсдэлийн үнэлгээ, эрчим хүчний аудитын дүгнэлт, зөвлөмж зэргийг үндэслэл болгон үйлдвэрлэлийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, алдагдлыг бууруулах, үр ашигтай байх зорилтуудын хүрээнд үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн хэдийгээр өндөр байгаа ч хөрөнгө санхүүгийн боломжийг тооцоолон, хийгдэх ажлуудыг эрэмбэлэн зайлшгүй хийгдэх ажлуудыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 30 багц ажил хийхээр төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. Үүнд:

- ✓ Зохион байгуулалтын талаар 7 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн
- ✓ Техник тоног, төхөөрөмж ашиглалт засварын талаар 18 багц ажил төлөвлөсөн, гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сургалтын талаар 5 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн байна.

ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Монгол Улсын Эрчим Хүчний сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/15 дугаар тогтоолоор 2023 оны Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтаар 219.7 сая төгрөгийн 13 багц ажил хийгдэхээр төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа.

- Их засвараар 101.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 багц ажил хийхээр төлөвлөн 100 хувь хийж гүйцэтгэсэн.
- Техник зохион байгуулалтын арга хэмжээгээр 39.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц ажил хийхээр төлөвлөн 100 хувь хийж гүйцэтгэсэн
- Хөрөнгө оруулалтаар 5 төрлийн тоног төхөөрөмж авахаар төлөвлөн 100 хувь худалдан авалт хийгдэж, ашиглалтад оруулсан.

Нийт их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажилд 206.2 сая төгрөг зарцуулсан байна.

УРСГАЛ ЗАСВАР:

Зуух, туслах тоноглол, шугам сүлжээний урсгал засвараар 20 багц ажил хийхээр төлөвлөж, 74.7 сая төгрөг зарцуулан 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Компанийн 2023 оны ИЗ, ТЗБАХ, ХО-ын гүйцэтгэл

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төгрөг/	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Гүйцэтгэлийн хувь
1.Их засвар						
1	Ус дулаан түгээх салаа шугам хэсэгчилж солих /ДХЗ-ДХ5/	м/Зхос	100	22,041.2	14,082.6	100%
2	Усан сан, гүний худгийн цахилгаан хангамжийн кабель шугам шинэчлэх	м	650	34,151.0	34,111.6	100%
3	Барилгын засвар хийх /утаа сорогчийн заалны дээвэр (120м2) засвар, 1 давхарын заалны цонх (18м2) шинэчлэх	багц	1	12,326.0	13,176.6	100%
4	Ус түгээх худгийн барилгын их засвар	багц	2	20,200.0	21,760.9	100%
5	Тосон таслуур №3-н портал солих	багц	1	4,555.5	3,795.8	100%
6	Үйлчилгээний машины засвар	багц	1	8,120.0	5,340.0	100%
ДҮН				101,393.7	92,267.5	100%
2.ТЗБАХ						
1	Цэвэр усны насос станцад давтамж хувиргуур суурилуулах	багц	2	19,976.0	19,976.00	100%
2	Цахилгааны тоолуурын хяналтын систем, төгсгөлийн цэгийн параметрийн мэдээлэл цуглуулах	багц	2	19,602.0	19,602.00	100%
ДҮН				39,578.0	39,578.0	100%
3. Хөрөнгө оруулалтаар						
1	Утаа сорогч /У6-41-11-90С 27700м3 3168Па/	ш	1	19,500.0	19,500.0	100%
2	Ул ширэм редуктор /GL-16P/	ш	1	15,000.0	15,000.0	100%
3	Ус зөөлрүүлэх цахилгаан фильтрийн удирдлагын блок	ком	1	7,500.0	7,500.0	100%
4	Бохир усны насос СД160/45 дүйцэхүйц	ком	2	19,300.0	17,800.0	100%
5	Усны сав бтн	ш	3	17,400.0	14,520.0	100%
ДҮН				78,700.0	74,320.0	100%
НИЙТ ДҮН				219,671.7	206,165.5	100.0%

Засварын ажлын гүйцэтгэл, үр өгөөжийн талаар:

1. Ус дулаан түгээх шугам хэсэгчилж солих ажлыг өөрсдийн ажиллах хүчээр хийж бүрэн дуусгасан



2. Усан санруу кабель шугам шинээр татаж ус хангамжийн эх үүсвэр, өргөх станцыг цахилгаан хангамжийн нөөц тэжээлтэй болгосон.



3. Барилгын засвар хийх /утаа сорогчийн заалны дээвэр /120м2/, 1 давхарын заалны цонх шинэчлэх /18м2/ ажлыг хийж дуусгасан.



4. Ус түгээх 3, 6 дугаар худгийн байрыг шинэчлэх ажлыг Өндөр шугам ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж ашиглалтад оруулсан



5. Тосон таслуур №3-н портал солих ажлыг ШГХК-аас техникийн туслалцаа авч, “ДСЦТС” ХК-ийн ажилтнуудтай хамтран хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулсан

Засварын
өмнөх



Засварын явц




Засварын
дараах



6. Үйлчилгээний Бонго-III маркийн автомашины мотор сольж, засвар үйлчилгээ хийлгэсэн.



7. Цахилгааны тоолуурын хяналтын систем, төгсгөлийн цэгийн параметрийн мэдээлэл цуглуулах ажлыг "Гэрлийн хэмнэл" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Тоолуур суурилуулалт хийгдэж дууссан.



8. Цэвэр усны насос станцад 2 ш давтамж хувиргуур суурилуулж Насос тур бүр давтамж хувиргууртай болсон.



9. Утаа сорогч /Y6-41-11-90C 27700м3 3168Па/ худалдан авч зуух №1-д суурилуулсан



10. Ус зөөлрүүлэх цахилгаан фильтрийн удирдлагын блок



11. Бохир усны насос 2-ыг худалдан авч тосгоны болон үйлдвэрийн бохир усны насос станцад суурилуулсан



12. Усны сав /6тн/ 2 ширхэгийг худалан авч УТХ 3, 6 дугаар худгуудад суурилуулсан.



2023 онд ИЗ, ТЗБАХ, ХО-аар хийгдсэн ажлын үр өгөөж

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Төлөвлөгөөт ажлын үр дүн
1.ИХ ЗАСВАР			
1	Ус дулаан түгээх салаа шугам хэсэгчилж солих /ДХЗ-ДХ5/	14,082.6	хэрэглэгчдийг дулааны эрчим хүч, цэвэр усаар тасралтгүй хангах найдвартай ажиллагаа сайжирна.
2	Усан сан, гүний худгийн цахилгаан хангамжийн кабель шугам шинэчлэх	34,111.6	Шарын гол сумын ус хангамжийн эх үүсвэр, өргөх станцын цахилгаан хангамж нөөц тэжээлтэй болсон ба тасралтгүй найдвартай ажиллагаатай хангагдсан.
3	Барилгын засвар хийх /утаа сорогчийн заалны дээвэр (120м2) засвар, 1 давхарын заалны цонх (18м2) шинэчлэх	13,176.6	Барилгын дээврээс ус гоожих асуудал бүрэн зогссон. Мөн үнс зайлуулах хэсгийн цонхнуудыг вакум цонхоор сольж байгалийн гэрэлтүүлэгтэй болгосноор цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарах нөхцөл бүрдсэн, заалны барилгын дулаан алдагдал багасч, ажлын байрны нөхцөл сайжирсан
4	Ус түгээх худгийн барилгын их засвар	21,760.9	Барилгын өнгө үзэмж сайжирч, дулаан алдагдал багасч цахилгаан эрчим хүч хэмнэлт гарах боломж бүрдсэн. Хэрэглэгчдийг эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангах орчин нөхцөл сайжирсан.
5	Тосон таслуур №3-н портал солих	3,795.8	Сумын ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгуудыг тасралтгүй ажиллуулах цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагаа хангагдсан.
6	Үйлчилгээний машины засвар	5,340.0	Үйлчилгээний машины ажлын бүтээмж нэмэгдэж, тээврийн зардал хэмнэгдэх боломж бүрдсэн
ДҮН		92,267.5	
2.ТЗБАХ			
1	Цэвэр усны насос станцад давтамж хувиргуур суурилуулах	19,976.00	Насос тур бүр давтамж хувиргууртай болж, Сумын ус хангамжийн тасралтгүй найдвартай ажиллагаа хангагдсан. Ашиглалтын зардал буурна
2	Цахилгааны тоолуурын хяналтын систем, төгсгөлийн цэгийн параметрийн мэдээлэл цуглуулах	19,602.00	Эрчим хүчний хэмнэлтийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан.Дотоод цахилгаан эрчим хүчний хяналт бүртгэлийн системийг сайжруулж, хэмнэлт гаргах нөхцөл бүрдсэн
ДҮН		39,578.0	
3.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			
1	Утаа сорогч /У6-41-11-90С 27700м3 3168Па/	19,500.0	Утаа сорогчийг суурилуулснаар зуухны найдвартай ажиллагаа хангагдан сумын дулаан хангамжийн тасралтгүй ажиллагаа дээшилсэн.
2	Ул ширэм редуктор /GL-16P/	15,000.0	Редуктор сольсноор зуух №1-ийн найдвартай ажиллагаа хангагдана. Мөн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдал, сумын дулаан хангамжийн тасралтгүй ажиллагаа дээшилсэн.
3	Ус зөөлрүүлэх цахилгаан фильтрийн удирдлагын блок	7,500.0	Ус зөөлрүүлэх цахилгаан фильтрийн найдвартай ажиллагаа хангагдаж сүлжээний усны хатуулгыг стандарт хэмжээнд барих боломж бүрдсэн.
4	Бохир усны насос СД160/45 дүйцэхүйц	17,800.0	Бохир ус татан зайлуулах найдвартай ажиллагаа сайжирч ашиглалтын зардал буурсан.
5	Усны сав бтн	14,520.0	Гэр хорооллын айл өрхийг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах ажиллагаа сайжирсан.
ДҮН		74,320.0	
НИЙТ ДҮН		206,165.5	

IV.ХАБЭА, АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТАЛААР ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР:

2023 онд ХАБЭА-н зардалд нийт 80 161.0 мянган төгрөг төлөвлөж 80 127.0 мянган төгрөг буюу 99,9%-ийн гүйцэтгэлтэй байна.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөж, ажилчдын сахилга, хариуцлага дээшлүүлэх талаар онцгой анхаарч, технологийн зөрчил, болзошгүй аварри саатлаас урьдчилан сэргийлж давхардсан тоогоор:


- Өдөр тутмын зааварчилгааг 2 893 удаа өгч 5 702 ажилтан
- Аварь эсэргүүцэх дасгалыг 21 удаа явуулж 365 ажилтан
- Осол эсэргүүцэх дасгалыг 32 удаа явуулж давхардсан тоогоор 459 ажилтан
- Ээлжит давтан зааварчилгааг 143 удаа өгч давхардсан тоогоор 585 ажилтан
- Ээлжит бус давтан зааварчилгааг 136 удаа өгч 387 ажилтан
- Гал эсэргүүцэх дасгалыг 10 удаа өгч давхардсан тоогоор 157 ажилтан тус тус хамрагдсан.

7 хоног бүрийн Пүрэв гаригийг ХАБЭА-н өдөр болгож бүх ажлын байруудаар үзлэг шалгалт хийж гарсан технологийн болон ХАБЭА-н зөрчил дутагдлын талаар алба хэсгийн инженер, механикт фото зургаар баримтжуулан албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлийг бичгээр авч биечлэн шалгаж байлаа. Ажлын байрны үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил бүрт албан даалгавар өгч зөрчлүүдийг, арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

Энэ зөрчлүүдээр 32 албан шаардлага өгч зөрчлийг арилгуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Аварри ослоос урьдчилан сэргийлж ажлын байрны I, II шатны үзлэгийг тогтмол хийж I шатны 317 удаагийн үзлэгээр 184 зөрчил, II шатны 128 удаагийн үзлэгээр 131 зөрчил илрүүлэн, илэрсэн зөрчлийг устгах арга хэмжээг шуурхай авч ажиллалаа.

2023 онд III шатны үзлэгийг төлөвлөгөөний дагуу 3 удаа зохион байгуулсан.





Үзлэгээр нийт 52 зөрчил илрүүлж, ажлын байрны нөхцөл сайжруулах арга хэмжээ авч ажиллах үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажилласан.

Нарядын системийн мөрдөлтөнд анхааран ажиллаж наряд, шийдвэрээр гүйцэтгэх ажлын жагсаалтыг гарган батлуулж, мөрдөн ажилласан.

2023 онд нийт 34 наряд, 4351 шийдвэрээр ажил гүйцэтгэсэн байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

➤ Нарядаар гүйцэтгэх ажлын болон тоноглолуудын аюулгүй ажиллагаа хариуцагч томилох тушаал төлөвлөн, албажуулсан.

➤ 4-р сарын 28-ны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө, төсөв гаргаж хэрэгжүүлж ажилласан. Энэ ажлын хүрээнд

➤ Хөдөлмөрийн тухай болон ХАБЭА-н тухай хуулийг танин мэдүүлэх, ХАБЭА-н аяныг сурталчлах соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан.

➤ Аяны арга хэмжээний хүрээнд дээд шатны байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнүүд болон, “Эрүүл аюулгүй ажил- Бидний суурь эрх “ Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцлоо.

➤ Ижил төстэй компанийн туршлага судлах, танин мэдэхүйн үйл ажиллагаа зохион байгуулж, Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг ижил төстэй байгууллагууд болох “Дархан Ус суваг” ХК, “Дархан дулааны сүлжээ” ТӨХК, “Дархан дулааны цахилгаан станц” ТӨХК-уудын үйл ажиллагаатай танилцаж, сайн туршлага судалсан.



➤ “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, хамтын гэрээний дагуу буцалтгүй тусламж олгох

- ХАБЭА болон технологийн зөрчлийн мэдээг эрчим хүчний яамны сайт болон холбогдох газруудад тухай бүр илгээж ажилласан.
- ХАБЭА-н тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн ажилтнуудад зааварчилгаа, дасгал, сургалт зэргийг явуулах ажлыг тухай бүрт зохион байгуулан явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.
- Технологийн схемүүдийг одоо ашиглагдаж байгаа схемтэй тохирч байхаар шинэчлэн боловсруулж, баталгаажуулах, тогтоосон хугацаанд шалгаж тэмдэглэл хөтлөдөг болгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Нарядын системийн мөрдөлтийг хангаж ажиллаж, байнгын хяналт тавин ажиллаж байна

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ХҮРЭЭНД

- Эрүүл мэндийн тухай хуулийг сурталчлан таниулах, амьдралын зөв хэв маяг /стресс зөв тайлах/ талаар сургалт, зөвлөмжийг ажилтнуудад хүргэн ажилласан. Үүнд
 - Ажилтнуудад эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сумын эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллаж байна.
 - Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран Тамхины хор хөнөөл, эрүүл мэнд, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх сургалтыг 2023 оны 05 сарын 16-ны өдөр зохион байгуулсан
 - Шарын гол сумын ЭМТ-тэй хамтран Сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн тухай сургалтыг мөн оны 11 сарын 10-ны өдөр зохион байгуулж, ажилтнуудынхаа эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд хамтран ажиллалаа.
 - Эрүүл мэндийг дэмжих, бялдаржуулах ажлын хүрээнд спортын арга хэмжээ, явган аялал зэргийг зохион байгуулсан





➤ Ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат болон урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, үзлэгийн мөрөөр эрүүл мэндийг хамгаалах ажлыг жил бүр зохион байгуулж эрүүл мэндийн зардлыг төсөвлөн ажиллаж байна.

- 2023 онд нийт 15,3 сая төгрөг төсөвлөсөн. Гүйцэтгэл 100%.

ХАБЭАМТөвтэй хамтран ажиллах гэрээний дагуу 2023 оны хугацаат үзлэгийг 8 нэр төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 7 нэр төрлийн параклиникийн шинжилгээ, 4 нэр төрлийн лабораторийн шинжилгээг хийж тэдний дунд тохиолдож буй ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг илрүүлэн оношилж, ажилтан гүйцэтгэж буй ажил мэргэжилдээ эрүүл мэндээр тэнцэх эсэхэд мэргэжлийн тохироог тодорхойлж ажиллалаа. Компанийн ажиллагсдын үзлэгт орвол зохих 74 хүнээс 73 хүн буюу 98.6 хувь хамрагдсан.

➤ Ажилтнуудыг нийтийн биеийн тамирын дасгал, идэвхтэй хөдөлгөөн, спортын уралдаан тэмцээнд оролцуулан чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

- Шарын гол сумын аж ахуйн нэгж байгууллагуудын дунд зохион байгуулсан шугаман бүжгийн тэмцээнд компанийн ажилтнууд идэвхитэй оролцож тэргүүн байр эзэлсэн амжилт үзүүлсэн.



- ОСНАА-н салбарын Төвийн бүсийн уулзалт зөвлөлгөөн ажил мэргэжил,спортын арга хэмжээнд компанийн ажилтнууд идэвхитэй оролцож багийн дүнгээр тэргүүн байрыг эзэлж, шилжин явах цомын эзэн болсон амжилтыг үзүүллээ.




- "Эрүүл агаар - Идэвхтэй хөдөлгөөн" сэдэвт ажилтнуудыг эрүүлжүүлэх, бялдаржуулан чийрэгжүүлэх цасны баярын арга хэмжээг зохион байгуулсан.



ГАМШГИЙН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ГАЛЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХҮРЭЭНД

Компанийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг МУШСайдын 120 -р тушаалын дагуу шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

2023 оны 06 сарын 08-ны өдрийн 16:00 цагт “Зарлан мэдээллийн дохио” дуугарч ажилтнууд түр цугларах талбайд гарч, аюулгүй байдлаа хангалаа.



Монгол Улсын Шадар сайдтай Дархан-Уул аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Шарын гол суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан. Иж бүрэн сургуулилтад иргэдийг нүүлгэн шилжүүлэх гамшгаас хамгаалах мэдлэг, мэдээлэл, хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлаа дээшлүүлэх арга хэмжээнд байгууллагын мэргэжлийн анги бүлэг идэвхитэй хамрагдаж, орон нутгийн гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги идэвх санаачилгатай оролцож, ажилласныг сургуулийн удирдагч, ОБГ-ын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа Х.Энхнасан дадлага сургуулийг дүүрэн хангалттай гэж дүгнэсэн.



V. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН ТАЛААР:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр тус компани зохион байгуулалтын 6 нэгжийн 44 албан тушаалд 101 ажилтан ажиллах ёстойгоос 41 албан тушаалд 84 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс 1 ажилтан нь хүүхэд асрах чөлөөтэй, 1 ажилтан жирэмсний болон амаржсаны амралттай байгаа тул ажлын байрыг нь хэвээр хадгалж байна. Мөн түүнчлэн хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр ерөнхий нягтлан бодогч, 1 цахилгаанчин, ажилладаг.

2023 онд шинээр 20 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, 21 ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалсан байна. Үүнээс өөрийн хүсэлтээр 10, шүүр ажиллагааны хүрээнд 1, ажил олгогчийн шийдвэрээр 1, өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор 2, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр 1, сахилгын шийтгэлээр 6 ажилтан хөдөлмөрийн гэрээгээ цуцалжээ. Сахилгын шийтгэлээр 11 ажилтан шийтгүүлснээс 1 ажилтны үндсэн цалинг 2 сар 20 хувиар, 2 ажилтан үндсэн цалинг 1 сар 20 хувиар, 8 ажилтныг нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулж шийтгэсэн байна.

Тайлант хугацаанд нийт ажилтнуудын хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийг тухай бүр хийж, шинээр орсон ажилтнуудыг програмд шивэх, баяжилт хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын хүний нөөцийг нөхөн бүрдүүлэх чиглэлээр нээлттэй ажлын байрны зарыг компанийн албан ёсны вэб хуудас dshggov.com болон Дулаан шарын гол facebook хуудсуудаар дамжуулан Шарын гол сумын хамгийн олон дагагчтай группүүдэд түгээж ажилласан. Нийт 16 ажлын байрны зар хүргүүлсэн.

Ажилтнуудын хөдөлмөр зүтгэлийг үнэлж Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон 1, Алтан гадас одонгоор 2, Хөдөлмөрийн хүндэт медаль 1, Эрчим хүчний салбарын тэргүүний ажилтнаар 3, Эрчим хүчний яамны жуух бичгээр 6, Эрчим хүчний тэргүүний мастер цол тэмдгээр 1, Найрамдлын дархан 2, Дархан-Уул аймгийн тэргүүний ажилтнаар 4, Дархан –Уул аймгийн Жуух бичиг 2, Шарын гол сумын хөдөлмөрийн аварга ажилтнаар 1, Шарын гол сумын хүндэт тэмдэгээр 4, Шарын гол сумын жуух бичгээр 3, Шарын гол сумын хүндэт өргөмжлөлөөр 1, нийт 31 ажилтныг шагнаж урамшуулсан байна.

Тус компанид удирдах дээд байгууллага болон харилцагч байгууллагуудаас хугацаатай 168, хугацаагүй 202, нийт 370 баримт бичиг ирүүлснийг хүлээн авч бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн өгч шийдвэрлүүлж ажилласан.

Компанийн зүгээс бусад иргэн, хуулийн этгээд 446 албан бичгийг хүргүүлж ажилласан байна. Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтлөлтийг хийж, цахим архив үүсгэн ажилласан.

Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахын тулд 155 тушаалыг гүйцэтгэх захирлаас гаргаж ажилласан байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 30 тушаал, хүний нөөцийн чиглэлээр 125 тушаал гарч, түүний хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

2023 онд хэрэглэгчдээс 37 өргөдөл, гомдол, санал ирүүлснээс 33 өргөдөл, гомдол, саналыг бүрэн шийдвэрлэсэн, 4 санал гомдол шийдвэрлэх шатандаа байна.


2023 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтуудад цахимаар болон танхимаар хамрагдаж, 7,465.0 мянган төгрөг төлөвлөсөнөөс нийт сургалтад 7,282.68 мянган төгрөг зарцуулсан байна.

- 2023 оны нийт ажилтны сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтуудыг тухай бүр авч, мэдээллийг хүргэж ажилласан. Мөн үндсэн үйлдвэрлэлийн ажилтнуудаас ААД болон ТАД-ээр холбогдох ээлжит болон ээлжит бус шалгалтуудыг авсан. Хангалтгүй үнэлгээ авсан ажилтнуудаас шалгалтын журмын дагуу 7-14 хоногийн хугацаа өгч, дахин шалгалт авсан ба шалгалт өгсөн ажилтнууд бүгд тэнцэж хангалттай үнэлгээ авсан. Давхардсан тоогоор 126 ажилтан хамрагдаж, хангалттай үнэлгээ өгсөн байна.

- Шинээр ажилд орсон ажилтнуудыг жинхлэх шалгалтад 7 ажилтан хамрагдаж хангалттай үнэлгээ аван үндсэн ажилтнаар томилогдсон.

Мэргэжлийн зэрэг ахиулах шалгалтын төлөвлөгөө гарган батлуулж, шалгалтын комиссын бүрэлдэхүүний хамт зэргийн шалгалтуудыг тухай бүр авсан. Зэргийн шалгалтад нийт 7 ажилтан хамрагдаж хангалттай үнэлгээ авч зэргээ ахиулсан.





Шарын гол сумаас зохион байгуулсан “НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-2023” нээлттэй хаалганы өдөрлөгийг тохиолдуулан “ХЭРЭГЛЭГЧЭЭ СОНСЪЁ” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Шарын гол сумын Найрамдал талбайд амжилттай зохион байгуулсан.



Дархан-Уул аймгийн засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний адрийн А/34 тоот захирамжийг үндсэлэн “Бүх нийтийн цэвэрлэгээний аян” зохион байгуулах ажлын хүрээнд байгууллагын эргэн тойрон 50м болон хуваарьт нийтийн эзэмшлийн зам талбайн шороо, хог хаягдлыг нийт 7 удаа цэвэрлэсэн.



Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 4/07 тоот хэрэглэгчийн аяныг хэрэгжүүлэх тухай албан бичиг, хорооноос 2023 оны өвлийн их ачааллын үед хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хариуцлага, үйл ажиллагааг дээшлүүлэх, шугам тоноглолд “Дулаан Шарын гол”ТӨХК

гарч болзошгүй гэнэтийн аваар, саатлын үед түргэн шуурхай арга хэмжээ авахад зөвлөмж, чиглэл өгөх зорилгоор зохион байгуулсан Хэрэглэгчийн аян-2023 аяны хүрээнд төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүдийг авч ажилласан.



VI. ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР :

2023 оны 01 дүгээр сарын 16 -ны өдөр “Дотоод хяналтын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дотоод хяналт шалгалтыг 7 бүлэг, 37 чиглэлийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн. Дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх захирлын байгуулсан ажлын хэсэг болон дотоод хяналтын ажилтан хийж гүйцэтгэн үр дүнг тухай бүр гүйцэтгэх захиралд танилцуулан, захирлын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажилласан. Үүнд: Хууль тогтоомжууд болон компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд 4 чиглэлээр хяналт тавьж, 4 зөвлөмж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд 9 чиглэлээр хяналт тавьж, 9 зөвлөмж, санхүүгийн үйл ажиллагаанд 3 чиглэлээр хяналт тавьж, 4 зөвлөмж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд 5 чиглэлээр хяналт тавьж, 4 зөвлөмж, байгаль орчны нөхөн сэргээлтэнд 4 чиглэлээр хяналт тавьж 2 зөвлөмж, Бусад чиглэлээр 1 зөвлөмж, нийт 20 зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтлөж, мэдээлэлийн сан бүрдүүлэн ажилласан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

П.БАЯРЦЭЦЭГ